

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/05/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Дарга тэргүүлэх аудитор: Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

БАЯНТАЛ СУМЫН "ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САН"-ГИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Г.АНХБАЯР ТАНАА

2022.02.15 № 48
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтал сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтал сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

073020150

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,998,210.39	20,137,510.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	24,698,210.39	5,837,510.39
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	24,698,210.39	5,837,510.39
31210	Төгрөг	24,698,210.39	5,837,510.39
31211	Төрийн сангийн харилцах	24,698,210.39	5,837,510.39
33	АВЛАГА	9,500,000.00	9,500,000.00
33500	Бусад авлага	9,500,000.00	9,500,000.00
33510	Байгууллагаас авах авлага	9,500,000.00	9,500,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	4,800,000.00	4,800,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	4,800,000.00	4,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,998,210.39	20,137,510.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,200,000.00	1,200,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,200,000.00	1,200,000.00
41300	Өглөг	1,200,000.00	1,200,000.00
41360	Бусад өглөг	1,200,000.00	1,200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,200,000.00	1,200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,798,210.39	18,937,510.39
51	Засгийн газрын хувь оролцоо	37,798,210.39	18,937,510.39
51200	Хуримтлагдсан үр дүн	37,798,210.39	18,937,510.39
51210	Өмнөх үеийн үр дүн	189,211,810.39	37,798,210.39
51220	Тайлант үеийн үр дүн	-151,413,600.00	-18,860,700.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,998,210.39	20,137,510.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	104,038,400.00	57,606,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	104,038,400.00	57,606,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	44,430,900.00	50,422,600.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	44,430,900.00	50,422,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,607,500.00	7,184,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,607,500.00	7,184,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	255,452,000.00	76,467,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,452,000.00	76,467,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255,452,000.00	76,467,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	246,967,300.00	67,448,920.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	246,967,300.00	67,448,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,484,700.00	9,018,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,484,700.00	9,018,380.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-151,413,600.00	-18,860,700.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-151,413,600.00	-18,860,700.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	184,891,810.39	184,891,810.39
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,320,000.00	4,320,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	189,211,810.39	189,211,810.39
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-151,413,600.00	-
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	37,798,210.39	37,798,210.39
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	37,798,210.39	37,798,210.39
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	37,798,210.39	37,798,210.39
8	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-18,860,700.00	-18,860,700.00
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	18,937,510.39	18,937,510.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	104,038,400.00	57,606,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	104,038,400.00	57,606,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	44,430,900.00	50,422,600.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	44,430,900.00	50,422,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,607,500.00	7,184,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,607,500.00	7,184,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,484,700.00	9,018,380.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,484,700.00	9,018,380.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,484,700.00	9,018,380.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,484,700.00	9,018,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,484,700.00	9,018,380.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	95,553,700.00	48,588,220.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	93,287,300.00	67,448,920.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	93,287,300.00	67,448,920.00
2200	Дотоод эх үүсвэрээр	93,287,300.00	67,448,920.00
223001	Бусад хөрөнгө	93,287,300.00	67,448,920.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-93,287,300.00	-67,448,920.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,266,400.00	-18,860,700.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,431,810.39	24,698,210.39
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,698,210.39	5,837,510.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,304,800.00	76,467,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,073,300.00	9,018,380.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,073,300.00	9,018,380.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,073,300.00	9,018,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,073,300.00	9,018,380.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,231,500.00	67,448,920.00
223001	Бусад хөрөнгө	70,231,500.00	67,448,920.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82,304,800.00	57,606,600.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,422,600.00	50,422,600.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	50,422,600.00	50,422,600.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,184,000.00	7,184,000.00
320001	Орон нутгийн төсвөөс	7,184,000.00	7,184,000.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,698,200.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,698,200.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	24,698,210.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	5,837,510.39

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн цахим төлбөрийн системтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 тоот албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянтал сумын ОНХС нь тайлант хугацаанд 82,304.8 мянган төгрөгийн нийт 10 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 76,467.3 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 255,452.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,831.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,682.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянтал сумын ОНХС-гийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,860.7 мянган төгрөгөөр буюу 48.36 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,698.21	5,837.51	(18,860.70)
Авлага	9,500.00	9,500.00	-
Бусад эргэлтийн хөрөнгө	4,800.00	4,800.00	-
Нийт хөрөнгө	38,998.21	20,137.51	(18,860.70)
Өр төлбөр	1,200.00	1,200.00	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	37,798.21	18,937.51	(18,860.70)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	38,998.21	20,137.51	(18,860.70)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,837.5 мянган төгрөг болж 18,860.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь зураг төсөв боловсруулах ажлын 2,000.0 мянга, сумын төвийн хог хаягдлын менежментийн зардлыг сайжруулах зардал 2,965.0 мянга, орон нутгийн суурь зарлагын хэмнэлт 174.0 мянга, гэрээний хэмнэлт 698.5 мянган төгрөг үүссэнтэй холбоотой.

Авлага, бусад эргэлтийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Эздийн өмч данс 18,860.7 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянтал сумын ОНХС-гийн 2021 онд хэрэгжүүлэх төсвийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Сумын 2021 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолоор шинээр эхлэх хөрөнгө оруулалт 37,650.0 мянга,

хөтөлбөр, төсөл арга хэмжээ 12,073.3 мянга, дутуу ажлын санхүүжилт 23,000.0 мянга, нийт 72,723.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 08 тоот тогтоолоор шинээр эхлэх хөрөнгө оруулалт 56,533.3 мянга, хөтөлбөр төсөл, арга хэмжээний зардал 25,073.3 мянга, дутуу ажлын санхүүжилт 698.2 мянга, нийт 82,304.8 мянган төгрөг болгон 9,581.5 мянган төгрөгөөр бууруулан баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт” хөтөлбөрийн 80918-Бусад арга хэмжээнд 70,231.5 мянга, 83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал-12,073.3 мянга, нийт 82,304.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 50,422.6 мянга, орон нутгийн төсвөөс 7,184.0 мянга, эхний үлдэгдлээс 24,698.2 мянган төгрөгийн санхүүжилт авч 76,467.3 мянган төгрөгийг зарцуулж, 5,837.2 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	80918-Бусад	70,231.50	67,448.90	2,782.60
	83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал	12,073.30	9,018.40	3,054.90
Нийт дүн		82,304.80	76,467.30	5,837.50

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянтал сумын ОНХС нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

3.8 Аудитын гол асуудал

Илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сан нь 2021 онд нийт 197,497.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг байршуулахаас 197,497.5 мянган төгрөгийн 146 мэдээллийг бүрэн байршуулж, 11 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сан нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 05 сарын 25-ны 197 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,430.8 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 11,430.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулга хийгдээгүй.

4.2. Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3. Албан шаардлага

4.3.1. Цахим төлбөрийн системд хяналт тавьж ажиллаагүй. 1 ААН-н 9,591.5 мянган төгрөгийн худалдан авалт шивэгдээгүй, 2 байгууллага 1,839.3 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү бичигдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээлэл хугацаа хоцроож, 5 мэдээлэл мэдээлээгүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.4, 6.3.9, 6.4.1, 6.2.4 дах заалтыг тус тус зөрчсөн.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг хугацаанд нь байршуулж байх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянтал сумын Засаг даргын Тамгын газар	2	11,430.8	-	-	-	-	1	11,430.8	1	-